



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2012-12-25 № 02/157 НОС.САГ/2012/31 СТД

**“МИАТ” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Г.ЖАРГАЛСАЙХАН
ТАНАА**

Зөрчлийг арилгуулах тухай

Зам тээврийн яамны харъяа “МИАТ” ТӨХК-ийн 2013 оны санхүүгийн тайланд аудит хийх явцад дараах зөрчил дутагдал илэрлээ. Тухайлбал:

- ✓ Худалдан авалтын төлөвлөгөөг харьяа газар, хэлтэс, тасгийн захиалгыг авч нэгтгэж, ТУЗ-аар батлуулж ажиллаж байгаа боловч нэмэлт гэрээгээр шууд худалдан авалтыг хийж, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох журмыг мөрдөж ажиллаагүй байна. Жишээ нь: Компьютер, түүний сэлбэг хэрэгсэл, тавилга эд хогшил, зарим төрлийн бараа материал гэх мэт. Энэ нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 5-ийг зөрчсөн байна.
- ✓ Ашиглалтын хугацаа дууссан хөрөнгө нийт үндсэн хөрөнгийн 40.6 хувийг эзэлж байгаа нь төрийн өмчийн хөрөнгийн үнэ цэнийг бууруулж, санхүүгийн үзүүлэлтэд муугаар нөлөөлж байна.
- ✓ Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу дотоод аудитын нэгжийг байгуулж ажиллаагүй, компанийн дотоод хяналт сул байна.
- ✓ 2013 онд Төлөөлөн удирдах зөвлөл удаа дараа хуралдаж, шийдвэр гаргаж байгаа боловч энэ талаар үр дүн муу, шийдвэртээ хяналт тавьж ажиллахгүй байна.
- ✓ “МИАТ” ТӨХК-ний үнэлгээний хороо “Боинг 737-800, EI-CXY, “Боинг 737-300, JU1011, “Боинг 737-300 JU1012 агаарын хөлгүүдийн иж бүрэн даатгалын үйлчилгээ үзүүлэх компанийг сонгон шалгаруулахаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу нээлттэй тендер явуулж “Бодь даатгал” ХХК нь хамгийн сайн гэсэн үнэлгээгээр шалгарсан байна.

“МИАТ” ТӨХК нь Бодь даатгал компанид 2013 онд төлбөр тооцоог шилжүүлэхдээ шилжүүлэг хийсэн тухайн өдрийн Монгол банкны ханшаар тооцож нийтдээ 1,632.7 мянган ам.доллар буюу 2,444.4 сая төгрөг шилжүүлжээ.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28.13 **“Тендерийн баримт бичигт зааснаас өөр гадаад валютыг төлбөр тооцоонд хэрэглэх бол түүнийг хөрвүүлэх**

0700002

ханшийг тендер зарласан өдөр Монгол банкнаас зарласан ханшаар тооцно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Гэтэл 2012 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн тендер зарласан албан ханш /1 ам.доллар/ 1,379.05 төгрөг байсан бөгөөд энэ ханшаар тооцвол 2,251.6 сая төгрөг болж 192.8 сая төгрөгийг илүү шилжүүлсэн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12 дахь “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмыг үндэслэн **АЛБАН ШААРДЛАГА** өгч байна.

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Засгийн газрын 2009 оны 93 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах, Төрийн өмчийн хорооны шийдвэргүйгээр аливаа хөрөнгө зардлыг гаргуулахгүй байх.
2. Ашиглалтын хугацаа дууссан хөрөнгийг холбогдох байгууллагаар нь албан ёсны шийдвэр гаргуулж үнэлүүлэх
3. Дотоод хяналтыг сайжруулах
4. Төлөөлөн удирдах зөвлөл болон Хяналтын албаны үүрэг хариуцлагыг чанаржуулах
5. “Бодь даатгал” ХХК-д илүү шилжүүлсэн даатгалын үйлчилгээний төлбөрийн гүйцэтгэлийг 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар тооцоо нийлж, тооцоо нийлсэн актыг 2014 оны 3 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

Ахлах аудитор



Ц.Сугармаа